МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХҮЙСИЙН ТЭГШ ЭРХИЙН ТӨВ

KOREA Official Development Assistance

Ministry of Gender Equality and Family

The Asia Foundation

# Цахим бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл гэж юу вэ?



## ХЭРЭВ ТА АЮУЛТАЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ОРСОН БОЛ ЯАХ ВЭ?

Хэрэв танд учруулж буй заналхийлэл бодитой гэж үзэн, өөрийгөө аюултай байдалд орлоо гэж бодвол дараах байгууллагууд хандана уу. Үүнд:

| 102 | 108 | 1800–1903 | 70159688 |
|---|---|---|---|
| Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах утас | Хүүхдийн тусламжийн утас | Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх утас | Насанд хүрээгүй бэлгийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх утас |

## ЦАХИМ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Цахим орчинд үйлдэгдэж буй бүх төрлийн бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллийн үйлдлүүд нь хууль зөрчсөнд тооцогдоно.

Цахим орчинд үйлдэгдэж буй бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг гэдэг нь хэн нэгэн этгээд сэтгэл зүйн болон бие махбодын хүчирхийлэл хийх замаар бусдаар бэлгийн ямар нэгэн үйлдэл хийлгэж буй явдлыг хэлдэг. Тухайлбал, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх замаар бэлгийн ямар нэгэн үйлдэл хийж буй зураг, бичлэгийг өөр рүүгээ явуулахыг шахаж шаардах, эсхүл шууд бичлэг хийж байх явцад бэлгийн ямар нэгэн үйлдэл хийхийг шаардахыг хэлдэг.

## ЦАХИМ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ БОЛЖ БУЙ ЭСЭХЭЭ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ



Хэн нэгэн танихгүй хүн таныг хэзээ ч таагүй, эвгүй байдалд оруулах эрхгүй. Хэрэв хэн нэгэн этгээд таныг эвгүй байдалд оруулах, айлгах, сүрдүүлэх эсхүл ямар нэгэн зүйл хүчээр хийлгэх гээд байвал та бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн золиос болж байна гэсэн үг.

Таны харьцаж буй хүн таныг дараах арга замаар бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч болгох боломжтой. Үүнд:

- Танд тааламжгүй санагдаж байгаа ч таныг бэлгийн ямар нэгэн үйлдэл хийхийг өдөөн турхирах;
- Таныг хүсээгүй байхад нүцгэн хүний зураг явуулах, эсхүл таны дүрсийг камераар бичих;
- Таны бэлгийн амьдралын талаар асуулт асуух, эсхүл шалиг үг хэллэг ашиглан харилцах;
- Танаас зөвшөөрөл авахгүйгээр порно бичлэг хийхээр оролдох;
- Таныг зөвшөөрөөгүй байхад янз бүрийн бэлгийн үйл ажиллагаа харуулсан зураг, дүрс бичлэг үзүүлэх.

## ЦАХИМААР ҮЙЛДЭГДЭЖ БУЙ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ТӨРЛҮҮД



Энэхүү гэмт хэргийг үйлдэгчдийн гол арга барил, зарчмын талаар ойлголт, мэдлэгтэй болсноор та цахим бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл гэж юу болох талаар тодорхой ойлголттой болж чадна.

## ХАЛАМЖЛАХ



Халамжлах гэдэг нь гэмт этгээдийн зүгээс таны итгэлийг олж авахын тулд ашиглаж буй аргуудыг ерөнхийд нь нэрлэсэн нэршил юм. Тэд тантай харилцаагаа гүнзгийрүүлэхийн тулд тодорхой аргуудыг ашигладаг. Тухайлбал,

- Цаг үргэлж сайхан үг хэлж, магтах зэргээр эелдэг хандах (“Би чам шиг ийм хөөрхөн эмэгтэйтэй урьд нь ерөөсөө тааралдаж байгаагүй”, “Би өөр хэнд ч чамд хайртай байгаа шигээ дурлаж байгаагүй” гэх мэт);
- Хэтэрхий их анхаарал халамж тавих;
- Хэтэрхий сайхан сэтгэлтэй байх;
- Байнга бэлэг сэлт өгөх;
- Байнга мөнгө өгөх гэх мэт.

Хэдийгээр энгийн хүмүүсийн дунд дээрх харилцаа байдаг боловч хэрэв таны харилцаж буй хүн өөрийнхөө талаар бусдад хэлэхгүй байхыг гуйх, эсхүл худал хэлэхийг хүсэж байвал та хоёрын харилцаа нэг л буруу тийшээ яваад байгааг харуулна.

## СҮРДҮҮЛЭГ ХИЙХ



Хэн нэгэн хүн өөрт нь зориулж танаар ямар нэг юм хийлгэхийг хүсэж, хийгээгүй тохиолдолд таныг өвтгөх болно хэмээн заналхийлэхийг сүрдүүлэг хийх гэнэ. Сүрдүүлэг хийхдээ хүссэн зүйлийг нь хийхгүй бол таны секс зураг, бичлэгийг  олон нийтэд тараана гэх мэтээр заналхийлдэг.

## НАЙЗ ЗАЛУУ/ ОХИНЫ ДҮРД ТОГЛОХ

Гэмт этгээд танд ойртон дотносож, итгэл олж авахын тулд хуурамчаар найз залуу/охины дүрд тоглож эхэлнэ. Хэрвээ та хоёрын харилцаа итгэл төрүүлэхүйц биш санагдаж байвал та хоёрын хоорондын харилцааны мөн чанарт бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн бусад шинж тэмдэг илэрч байгаа эсэхэд анхаараарай.





## ХАЙР ХАЛАМЖИД БӨМБӨРҮҮЛЭХ

Хайр халамжаар бөмбөрүүлэх гэдэг нь гэмт этгээд таны хайр, итгэлийг олж авахын тулд хайр халамжийг харамгүй зарцуулж, хэтэрхий их анхаарал тавих явдлыг ойлгоно.

## УРХИДАХ

Гэмт хэрэгтнүүд нь ихэнхдээ  амар, хялбар аргаар өөрийн эршээлдээ оруулах боломжтой, насанд хүрээгүй гэж таамаглаж буй хүнтэй холбогдож, холбоо харилцаа тогтоох явдлыг ойлгоно. Тиймээс хэн нэгэн тантай танилцах, дотно харилцаа тогтоох талаар байнга санал тавивал энэ тухай өөрийн итгэдэг насанд хүрсэн хүн (эцэг эх, асран хамгаалагч, багш, зөвлөгч гэх зэрэг)–д тухай бүр мэдэгдэж байх хэрэгтэй. Эсхүл тухайн гэмт хэрэгтний талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

## САЛЖ ӨГӨХГҮЙ БАЙХ

Хэрэв хэн нэгэн таныг “үгүй” гэсээр байхад тасралтгүй ямар нэг зүйл хийхийг шалах явдлыг “Салж өгөхгүй байх” гэж ойлгож болно. Энэ тохиолдолд та “үгүй” гэсэн шийдвэртээ үнэнч байх, эсхүл тухайн этгээдийг хаягийг блоклох зэрэг арга хэмжээг авч болно. Хэрэв та тухайн этгээдийн хүссэнээр өөрийн бэлгийн амьдралтай холбоотой ямар нэгэн зураг, бусад зүйлийг түүнд илгээвэл, түүнийг чинь ашиглаад тэд хэзээ нэгэн цагт таныг айлган сүрдүүлэх арга тактик ашиглах болно гэдгийг анхаарна уу.



## ГЭМШИХ СЭТГЭЛИЙГ ЧИНЬ АШИГЛАХ

Гэмт этгээд өөрийг чинь ямар нэгэн зүйлд буруутгах, таны хийсэн үйлдэл түүнийг гомдоосон хэмээн итгүүлэх зэрэг аргуудаар танд гэмших сэтгэгдэл төрүүлж түүгээр дамжуулан хүссэн зүйлээ хийлгэхээр улайрахыг хэлнэ.

## САДАР САМУУНД УРУУ ТАТСАН МАТЕРИАЛ ЯВУУЛАХ




Гэмт этгээд тань руу садар самуунд уруу татсан ямар нэг зүйл явуулах (порнограф, өөрийнхөө нүцгэн байгаа зураг гэх мэт) зэргээр та хоёрын дунд иймэрхүү харилцаа ердийн зүйл гэсэн ойлголт төрүүлэхийг оролдож магадгүй.

## ТАНЫ НУУЦЫГ АГУУЛСАН ЗУРАГ, БИЧЛЭГИЙГ АШИГЛАН МӨНГӨ, ЭД ЗҮЙЛ АВАХААР ШААРДАХ




Гэмт этгээд таны биеийн аль нэг хэсгийг харуулсан зураг, бичлэгийг ашиглан, танаар хүссэн зүйлээ хийлгэхийг шахаж шаардах явдлыг "Таны нууцыг агуулсан зураг, бичлэгийг ашиглан мөнгө, эд зүйл авахаар шаардах" гэнэ. Тухайлбал, тэд таны хагас болон бүтэн нүцгэн зургийг интернетээр олон нийтэд цацна хэмээн сүрдүүлж,

- Мөнгө нэхэх;
- Дахин нүцгэн зураг, бичлэг явуулахыг шаардах;
- Биечлэн уулзахыг шаардах зэргээр заналхийлж болзошгүй.

Таны нууцыг агуулсан зураг, бичлэгийг ашиглан мөнгө, эд зүйл авахаар шаардах, илчлэхээр айлган хүслээ гүйцэлдүүлэх болон бусад хэлбэрийн цахим бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллийг хууль бус үйлдэлд тооцдог. Ийм төрлийн гэмт хэрэгт өртсөн тохиолдолд та бусдаас туслалцаа авах бүрэн боломжтой.

## ЦАХИМ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖТОЙ ВЭ?



**Энэ төрлийн гэмт хэрэгтэй та ганцаараа тэмцэх шаардлагагүй. Хэрвээ та насанд хүрээгүй бол тухайн гэмт хэргийн талаар өөрийн итгэдэг хэн нэгэн насанд хүрсэн хүнд хандаж юу болоод буй талаар хэлэх хэрэгтэй.**

Энэ гэмт хэргийн хохирогч болсон үед хүмүүс ганцаардлыг илүү их мэдэрч, хэн ч туслахгүй юм шиг санагддаг. Гэвч хэн нэгнийг цахим бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд туслалцаа үзүүлэх үүрэгтэй маш олон байгууллага, хүмүүс байдаг. Тиймээс та хүнд байдлаас гарахын тулд тэдгээр байгууллага, хүмүүст хандаарай.

Хэрэв та Таны нууцыг агуулсан зураг, бичлэгийг ашиглан мөнгө, эд зүйл авахаар шаардах, илчлэхээр айлган хүслээ гүйцэлдүүлэх болон бусад хэлбэрийн цахим бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол дараах зүйлст анхаарлаа хандуулах шаардлагатай. Үүнд:

- Ямар нэгэн заналхийлэлд хэзээ ч хариу бүү өг:
  Гэмт этгээд таныг дайрч давшлан, айлган сүрдүүлж байсан ч түүнд хариу бүү өгөөрэй.
- Гэмт этгээдтэй тогтоосон бүх харилцаагаа зогсоо:
  Тэр тань руу ямар нэгэн байдлаар зурвас илгээх, захидал явуулах зэрэг оролдлого хийвэл бүү хариулаарай. Мөн түүнтэй харилцаж байсан цахим хаягийг нь блоклоорой.
- Тухайн хүнтэй харилцаж байсан бүх цахим хаягаа идэвхгүй болго:
- Та тухайн этгээдтэй харилцаж байсан цахим орчин дахь бүх хаягаа идэвхгүй болгоорой.
  Харин тухайн этгээдтэй холбогдож байгаагүй, түүний мэдэх өөр хаяг байгаа бол аюулгүй байдлыг дахин сайтар нягтлаарай.
- Тухайн этгээдийн талаар насанд хүрсэн хүнд хэлэх:
  Та түүний талаар өөрийн эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч, зөвлөгч, гэр бүлийн бусад насанд хүрсэн хүн зэрэг аль нэг итгэдэг хүндээ хэлээрэй.

## ХЭН НЭГЭН ТАНЫ ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР ТАНЫ ЗУРАГ БИЧЛЭГИЙГ БУСАДТАЙ ХУВААЛЦСАН ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?



Хэн нэгэн таны зөвшөөрөлгүйгээр нууц зураг, бичлэгийг чинь бусдад тараасан явдал нь таны буруу биш гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй. Ямар ч хүн хэн нэгэн өөрийнх нь итгэлийг алдах, хувийн нууц нь бусдад дэлгэгдэхийг хүлээн зөвшөөрдөггүй. Хамгийн гол нь та ийнхүү мэдээлэл олон нийтэд цацагдсан явдлын эсрэг авах арга хэмжээг удаашруулах , бусдаас нууцлах тусам тэрхүү мэдээлэл олон нийтэд тэр хэмжээгээр удаан хугацаагаар нээлттэй хэвээр л байж, тухайн асуудлыг зохих ёсоор шийдвэрлэх боломж хумигдсаар байдаг. Тиймээс таны мэдээлэл олон нийтэд илүү өргөн хүрээнд тархахаас өмнө дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Тухайлбал,

- **Тухайн зураг, бичлэгийг олон нийтийн сүлжээнээс авахуулах талаар арга хэмжээ авах**
  Тухайн зураг, бичлэгийг анх цацсан вэбсайт руу хандаж тэдгээрийг олон нийтийн сүлжээнээс татуулах хүсэлт гаргах.
- **Хэрвээ та хүүхэд бол насанд хүрсэн хэн нэгнээс тусламж авах.**
  Та итгэж болохоор гэж үзсэн хүнд хандаж тусламж хүсэхдээ түүнд тухайн зураг, бичлэгийг заавал үзүүлээд байх шаардлагагүй. Зөвхөн юу болоод байгаа тухай хэлэхэд л болно.
- **Өөрийгөө хамгаал.**
  Таны мэдээллийг агуулсан зураг, бичлэгийг цахимаар бусдад дамжуулж буй гэмт этгээдтэй тогтоосон харилцаагаа блокло. Хэдийгээр тэдгээр хүмүүс тэвчихийн аргагүй зүйл бичиж тань руу дайрч давшилж байсан ч тэдэнтэй битгий харьц. Учир нь тэр бүхэнд нь хариу бичсэнээр асуудлыг бүр илүү хүндрүүлэх болно.
- **Бусдаас тусламж хүс.**
  Таныг бусад хүн дарамтад оруулж, мөлжлөгт өртүүллээ гээд та тэдний бодсон шиг хүн болохгүй. Хамгийн гол нь та бусдаас тусламж авч, өөртөө санаа тавих хэрэгтэй.

## ЦАХИМ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДАД МЭДЭЭЛЭХ




Хэрвээ та 18 насанд хүрээгүй бөгөөд насанд хүрсэн хүнд цахим бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллийн талаараа хэлсэн бол таны хандсан хүн энэ талаарх мэдээллийг холбогдох байгууллага, хүмүүст мэдээлэх хэрэгтэй.

______ /______ /______

______ /______ /______

______ /______ /______

_______ /_______ /_______

Цахим бэлгийн мөлжлөг,
бэлгийн хүчирхийллийг
таслан зогсооё



# 1800-1903

